



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/52

Булган сум

### Журам, болзол дүгнэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 4.1, аймгийн Засаг даргын “Журам шинэчлэх тухай” 2022 оны А/435 дугаар захирамж, аймгийн Засаг даргын “Журам шинэчлэн батлах тухай” 2021 оны А/30 дугаар захирамж, аймгийн Засаг даргын Удирдлагын багийн 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тоот хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан, тогтвортой амжилт гаргасан Тэшиг сумын тариаланч Цэгмэдийн Цэрэн-Очирыг аймгийн аварга тариаланчаар, Гурванбулаг сумын Агьт багийн малчин Дуйнхаржавын Баасанжав, эхнэр Чимэддоржийн Энхжаргал, Тогоо багийн малчин Лувсангэндэнгийн Баасансүрэн, эхнэр Цэнддоогийн Даваа нарыг аймгийн аварга малчнаар тус тус шалгаруулсугай.

2.Шагналын зардлын тооцоог хавсралтаар баталж, шаардагдах 2,100,000 (хоёр сая нэг зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 05-ны өдрийн 71/02 дугаар  
захирамжийн хавсралт



ШАГНАЛД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТООЦОО

Д/д	Нэрс	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ /мян.төг/
1	2	3	4	5
1	"Аймгийн аварга малчин өрх"	2	800,000	1,600,000
2	"Аймгийн аварга тариаланч"	1	500,000	500,000
	<b>Нийт</b>	<b>3</b>		<b>2,100,000</b>